ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/169НА-СТА-ТШЗ

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг:erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Э.Сүнжидмаа
Утас: 80048599 Цахим хаяг:Sunjidmaae@audit.gov.mn

Цахим хуудас:
www.audit.mn
Алтай хот
2024 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/
ГАА-2024/169/НА-СТА-ТШЗ

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 110

танай_____ -ны №_____ -т

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА М.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд орон нутгийн өмч хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийг зохицуулах 6 журам баталсан бөгөөд хэм хэмжээний актаар бүртгүүлэхээр Хууль зүй дотоод хэргийн яамд хүргүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 136,978.5 мянган төгрөгөөр өссөн нь төрийн албан хаагчдын цалин, хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 6 зорилт, 47 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга 98.0 хувиар үнэлсэн байна.

0702000358

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /мян.төгрөгөөр/

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	95,315.3	60,816.7
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	171,284.5	153,859.6
	Нийт хөрөнгийн дүн	**266,599.9**	**214,676.3**
	Нийт өр төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	266,599.9	214,676.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	**266,599.9**	**214,676.3**
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,389,335.9	1,249,692.5
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,278,414.7	1,265,156.4
	Үйл ажиллагааны үр дүн	**110,921.1**	**(15.463.9)**
	Үйл ажиллагааны бус үр дүн	**44.900.0**	
	Үйл ажиллагааны нийт үр дүн	**66,021.1**	**(15.463.9)**
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	200,578.7	230,140.2
	Тайлант оны үр дүн	66,021.1	(15.463.9
	Эцсийн үлдэгдэл	266,599.9	214,676.3
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,389,335.9	1,230,952.5
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,251635.9	1,149,253.5
	Үйл ажиллагааны ЦМГ	**137,700.0**	**81,699.0**
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	**(137,700.0)**	**(81,699.0)**
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	**1,155,992.1**	**1,111,230.4**
	Урсгал зардал	1,155,992.1	1,111,230.4
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	**1,257,930.6**	**1,158,140.2**
	Улсын төсвөөс санхүүжих		
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,257,930.6	1,158,140.2
	Үндсэн үйл ажиллагааны орлого		

Гурав:. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 13,906.8 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдааг аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Тайлант оны үндсэн хөрөнгийн 10-12 сарын 13,906.8 мянган төгрөгийн элэгдлийг тооцоолоогүй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах",Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг

баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна

Залруулагдаагүй нийт 3,847.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 3,847.0 мянган төгрөгийн 4 зөрчил илэрч, 1,539.1 мянган төгрөгийн төлбөрийн акт, 2,307.9 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Ээлжийн амралт, цалин давхардуулан 175.1 мянган төгрөгийг илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно.", Тухайн цалин, нэмэгдэл тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэрийг нэмж тусгана. Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.1-т "Ээлжийн амралтын цалинг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлснөөс тооцож олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайдын 2021 оны А/19 дүгээр тушаалын хавсралтын 3 дугаар зүйлийн 3.4-т "Ээлжийн амралтын цалинг тооцохдоо өмнө эдэлсэн ээлжийн амралтаас хойш ажилласан саруудын цалин хөлсний нийлбэрийг, тухайн саруудад ажилласан ажлын өдрийн нийлбэр тоонд хуваан ажлын нэг өдрийн дундаж цалин хөлсийг гаргаж ээлжийн амралтын өдрөөр үржүүлж бодно" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон

2. Албан томилолтын зардлыг 1,364.0 мянган төгрөг илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон томилолтыг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон

5.2 Албан шаардлага

1. Жилээс дээш насжилттай 30,815.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр

дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"-гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тооцоо нийлж, авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлсэн

2. Тавилга, аж ахуй эд хогшил дансанд 1,699.9 мянган төгрөгийн канон, 110.0 мянган төгрөгийн толь, 498.0 мянган төгрөгийн хөшиг бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн бүртгэлийн нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүртгэх ажиллах албан шаардлага хүргүүлсэн

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс: Залруулсан		Үүнээс: Залруулаагүй		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Тайлант оны үндсэн хөрөнгийн 10-12 сарын 13,906.8 мянган төгрөгийн элэгдлийг тооцоолоогүй байна.	1	13,906.8	1	13,906.8	-	-	1	13,906.8	-	-	-	-
	Дүн	1	13,906.8	1	13,906.8	-	-	1	13,906.8	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	**Алдаа, зөрчлийн товч утга**	**Нийт алдаа, зөрчлийн дүн**		**Үүнээс:**							
		Тоо	**Дүн**	**Төлбөрийн акт**		**Албан шаардлага**		**Зөвлөмж**		**Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн**	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Жилээс дээш насжилттай 30,815.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлээгүй	1				1		-	-	-	-
	Тавилга, аж ахуй эд хогшил дансанд 1,699.9 мянган төгрөгийн канон, 110.0 мянган төгрөгийн голь, 498.0 мянган төгрөгийн хөшиг бүртгэсэн байна.	1	2,307.9			1	2,307.9	-	-	-	-
	Ээлжийн амралт, цалин давхардуулан 175.1 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.	1	175.1	1	175.1			-	-	-	-
	Албан томилолтын зардлыг 1,364.0 мянган төгрөг илүү тооцож олгосон	1	1,364.0	1	1,364.0			-	-	-	-

дүн	**4**	**3,847.0**	**2**	**1,539.1**	2	**2,307.9**			-	-

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал */мянган*
төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	**Алдаа, зөрчлийн товч утга**	**Нийт алдаа, зөрчлийн дүн**		**Үүнээс:**							
		Тоо	**Дүн**	**Төлбөрийн акт**		**Албан шаардлага**		**Зөвлөмж**		**Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн**	
				Тоо	**Дүн**	**Тоо**	**Дүн**	**Тоо**	**Дүн**	**Тоо**	**Дүн**
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд 1,283.3 мянган төгрөгийг дутуу шивсэн	1	1,283.3	-	-	1	1,283.3	-	-	-	-
Дүн		1	1,283.3	-	-	1	1,283.3	-	-	-	-